

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаан 2020 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр хуралдаж аймгийн орон нутгийн 2020 оны тодотгосон төсвийг хэлэлцэн батлах тухай, Зарим газрыг улсын тусгай хамгаалалтанд авах тухай /Эрдэнэбулган сумын Булган уулыг дархан цаазат газар болгох, Өлзийт сумын Харганын хөндийд байрлах Луут хотын туурь орчмыг улсын тусгай хамгаалалтанд авах/ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 9-р сарын 28-ны өдрийн 14.00 цагт аймгийн ЗДТГ-ын VIP танхимд зохион байгуулж, зөвлөгөөнөөр агентлагийн 2020 оны үйл ажиллагааны явцын үнэлгээний дүн, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, корона вируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа арга хэмжээ, цаашид авах арга хэмжээний санал, мэдээллийг аймгийн ЗДТГ, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газраас танилцууллаа.

Зөвлөгөөний төгсгөлд аймгийн Засаг дарга өвөлжилтийн бэлтгэл хангах, томуу томуу төст өвчин, корона вируст халдвараас урьдчилан сэргийлэх, 2-р ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулах, Эрдэнэбулган сумын тохижилт, соёлжилт, гэрэлтүүлгийг сайжруулах зэрэг чиглэлээр 8 үүрэг даалгаврыг агентлаг, байгууллагын дарга нарт өгөв.

Аймгийн Засаг даргын ивээл дор “Номын баяр-2020” арга хэмжээг аймгийн соёлын байгууллагууд хамтран 9-р сарын 19-ний өдөр аймгийн Биеийн тамир, спортын газарт зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 2000 гаруй иргэн оролцсон бөгөөд “Аз хур” ХХК-иас 72 хувь хүртэлх хямдралтай 612 нэр төрлийн 70000 гаруй номын худалдааг зохион байгуулсан.

Улсын Онцгой комиссын 2020 оны 9-р сарын 14-ний өдрийн 29 дүгээр хурлын шийдвэрийн дагуу “Бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 9-р сарын 16-ны өдрийн А/644 дүгээр захирамжийг гарган, коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг хэсэгчлэн шилжүүлэх хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд сунгаж, соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүллээ.

Мөн захирамжаар олон нийтийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээг коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг холбогдох дүрэм, журам, зааврын дагуу хийх, цар тахлын талаарх мэдээлэл, ойлголт, сургалт сурталчилгааг чанартай зохион байгуулж ажиллахыг холбогдох газруудад үүрэг болгосон.

9-р сарын 24, 25-ны өдрүүдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй "Ногоон алт малын эрүүл мэнд" төслийн хүрээнд "Эрүүл бэлчээр-Эрүүл мал-Эрүүл хүнс" сэдэвт төвийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Зөвлөгөөнд Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Швейцарын хөгжлийн агентлагийн дарга Стефани Бурри, аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасан, холбогдох мэргэжилтнүүд, Архангай, Өвөрхангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумын хувийн мал үржлийн ажил үйлчилгээний аж ахуйн нэгжийн мал зүйч, мал эмнэлгийн малын эмч нар, нийт 250 гаруй хүн оролцсон байна.

Зөвлөгөөний 2 дахь өдөр малыг бүртгэлжүүлэх, малын тэжээл чанар, хангамжийг нэмэгдүүлэх, мал сүргийн ашиг шим, тэсвэрт чанарыг сайжруулах, малын тоог эргэлтийн тооцооллын дагуу бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр Ихтамир сумын малчны хотонд үзүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Архангай аймгийн Засаг даргын 2020 оны А/635 дугаар захирамжаар баталсан “Улсын төрөлжсөн олимпиад, элсэлтийн ерөнхий шалгалтанд амжилт гаргасан багш, сурагч, сургуулийг шагнаж урамшуулах журам”-ын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтын ур чадварын буюу хар зураг, дуу хөгжим, биеийн тамирын төрлүүдээр 750-800 оноо авсан 4 сурагч, тэднийг бэлтгэсэн 2 багшид, нийт 1125000 төгрөгийн урамшуулал олголоо.

“Архангай түншлэл” үзэсгэлэн худалдааг энэ жил 15 дахь жилдээ 9-р сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 11 сум, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Завхан аймгуудийн нийт 79 аж ахуйн нэгж, иргэд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, модон эдлэл, бэлэн хувцас, гар урлалын бүтээгдэхүүн, гэр ахуйн цахилгаан бараа, эсгий ноосон бүтээгдэхүүн зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалж, 45 сая 536 мянган төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

9-р сард улсын төсөвт 102590.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 103000.0 мянган төгрөгийг хүлээгдэж буй гүйцэтгэлээр төвлөрүүлж төлөвлөгөөг 100.3 хувиар, орон нутгийн төсөвт 824459.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 830000.0 мянган төгрөгийг хүлээгдэж буй гүйцэтгэлээр төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.6 хувиар биелүүлэхээр ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49.076.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 7-р сарын байдлаар 9.331.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Үүнээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 18.5 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 955.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 132.7 сая төгрөгийн 3, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гэрээ байгуулж эрх олгосон 328.3 сая төгрөгийн өртөг бүхий төсөл арга хэмжээний худалдан авалтийг зохион байгууллаа.

Орон нутгийн өмчит 34 төсөвт байгууллагад 58.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгож, 3 төсөвт байгууллагад 22.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх зөвшөөрлийг олгосон 12 байгууллагад 358 нэр төрлийн 291.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл олгосон.

Санхүүгийн хяналт

Санхүүгийн хяналт, аудитын албанаас Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулиудын үйл ажиллагаанд аудит хяналт шалгалт хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

9-р сард тус аймагт 3 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдсоноос объектын гал түймэр 1, зөрчил 1, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1 ирсэн байна.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалтыг аймгийн төвийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургууль-6, цэцэрлэг-15, их, дээд сургууль-1, МСҮТ-3, нийт 25 барилга байгууламжийн 31 объектод хийж гүйцэтгэн, Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын улсын хяналтын дүрэм, норм, журмын холбогдох заалтыг зөрчсөн 115 зөрчил илрүүлж, 57 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан 58 зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 25-ыг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.

Ихтамир суманд Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар хамтран хяналтын пост ажиллуулж, 1000 гаруй иргэнд 600 ширхэг санамж гарын авлага тарааж урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх 1, үер усны ослоос урьдчилан сэргийлэх 1, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 төрлийн шторкыг “АВ” телевизээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт 1000 минут нэвтрүүлсэн

Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын хүрээнд Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Зоонозын өвчин судлалын төв, Экологийн цагдаагийн алба хамтран “Тарваган тахал өвчнөөс сэргийлье”, “Хууль бусаар самар түүж, бэлтгэхийг хориглоно” урьдчилан сэргийлэх самбарыг бэлтгэн аймгийн төв зам дагуу байршууллаа.

2020 оны 8-р сард аймгийн хэмжээнд 332 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 86, хулгайлах гэмт хэрэг 151, иргэдийн өмчийн гэмт хэрэг 56, малын хулгайн гэмт хэрэг 83, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 19, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 58, гэмт хэргийн илрүүлэлт 36.5 хувьтай байна.

Нийт 19052 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 18474 иргэнд 603 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1230.9 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 38.6 хувьтай байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 9-р сард 2721756.4 төгрөгийн мөнгөн дүн бүхий 510 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 43.9, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 35.1 байна.

Шүүхийн шинжилгээний алба 9-р сард криминалистикийн шинжилгээ 2, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 32, шүүх эмнэлгийн шинжилгээ 34 шинжилгээ тус тус хийсэн байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс Эрдэнэбулган, Төвшрүүлэх сумдын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй, албан байгууллагын нийт 29 жин хэмжих хэрэгсэл, Эрдэнэбулган сумын 1 фазын тоолуур -30, 3 фазын тоолуур 4, нийт 34 цахилгаан хэмжих хэрэгсэл, Цахир суманд ашиглалт орсон “Магнай трейд” ХХК-ийн шатахуун түгээх станцын 2 түгээгүүрт баталгаажуулалт хийж гэрчилгээ олгосон байна.

Иргэний бүртгэл

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 195

Гэрлэлтийн бүртгэл - 19

Гэрлэлт цуцалсаны бүртгэл – 3

Эцэг тогтоосны бүртгэл - 5

Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 3

Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 14

Нас баралтын бүртгэл - 67

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 62

Дахин олгосон – 44

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 112 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэл

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 14

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 19

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 4

Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 102

Арилжааны гэрээ – 0

Худалдах худалдан авах гэрээ – 97

Бэлэглэлийн гэрээ – 11

Барьцааны эрхийн бүртгэл – 245

Өв залгамжлал – 5

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 7

Лавлагаа – 3

Бусад эрхийн бүртгэл – 12

Хуулийн этгээд

Шинээр бүртгүүлсэн – 7

Өөрчлөлт – 53

Тамганы хяналтын дугаар олгосон –7 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

“Хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/63 дугаар тушаалын дагуу 9-р сарын 21-ний өдөөс эхлэн танхимын сургалтын хэвийн зохион байгуулж байна.

Боловсрол, соёл, урлагийн газар 9-р сарын 23-25-ны өдрүүдэд “Бүтээлч багш”, “Бүтээлч байгууллага” арга хэмжээг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын нийт 123 багш оролцож, мэдлэг чадвараа сорьсон байна.

Соёл, урлаг

9-р сарын 01-нээс 10-р сарын 28-ны хугацаанд “Номын баяр-2020” арга хэмжээг зохион байгуулж, Нийтийн номын сангаас “Нөхдөдөө өгөх бидний зөвлөгөө ШТОРК” бэлтгэх уралдаан, “Ногоон дэлхий бидний ирээдүй” гар зургийн уралдаан, “Монгол хүн ба номын хэрэглээ” илтгэлийн уралдаануудыг Мэргэшсэн нягтлан бодогчдын Архангай дахь салбар, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А/43 дугаар тушаалаар батласан “Соёлын цаг” нөлөөллийн аяны нээлтийг 9-р сарын 18-ны аймгийн Нийтийн номын сан, Музей, Хөгжимт драмын театр хамтран зохион байгуулж Аймгийн Хөгжимт драмын театр Эрдэнэбулган сумын 8-р цэцэрлэгийн хүүхэд багачуудад уран бүтээлийн дээжээ өргөн барьж, Музей хүүхэд багачуудад 4 төрлийн оньсон тоглоом, монголын уламжлалт тоглоом наадгайн нэг болох Үүчүүр, Аргал, янгир, шагайн тоглоомыг зааж, сургаж тоглуулж, Нийтийн номын сан хүүхдийн номын үзэсгэлэн гарган, хөгжөөнт тоглоом тоглуулж соёл урлагийн байгууллагууд үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилан таниуллаа.

Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 8 сарын байдлаар нийт 220043 үзлэг хийгдсэнээс бодит тоогоор 77045 буюу 35 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд эхний 8 сарын байдлаар халдварт өвчний нийт 242 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 125 тохиолдлоор буурсан.

Цочмог халдварт өвчин 116 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор буурсан. Архаг халдвар өвчин 126 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 106 тохиолдлоор буурсан байна.

2020-2021 оны томуу томуу төст өвчний улирал угтуулан 2020 оны 38-р 7 хоногоос эхлэн ТТӨ-ий харуулдан тандалтын 7 хоногийн мэдээг эрүүл мэндийн байгууллага /ЭМБ/-аас авч нэгтгэн 2019 оны 38-р 7 хоногоос эхлэн сум, өрхийн ЭМТ-үүдэд эргэн мэдээлэл хүргүүлэх, 2020-2021 оны ТТӨ-ий дэгдэлтийн улирлыг угтуулан бэлэн байдлаа хангах үйл ажиллагааны чиглэлээр 3 бүлэг 31 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан ЭМГ-ын даргын 2020 оны 9-р сарын 22-ны өдрийн 126 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх, албан байгууллага аж ахуй нэгжийн дарга нарт ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 бүлэг заалт бүхий зөвлөмж өгөх, Боловсрол соёл урлагийн газарт ТТӨ-ий улирал угтуулж болон дэгдэлтийн үед сургууль, цэцэрлэгийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, зөвлөмж хүргүүлэх, ХӨСҮТ-д эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг хүргүүлэх, улирлын томуугийн эсрэг вакцин татан авч, дархлаажуулалт хийх бэлтгэл ажлыг хангах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 9 сарын байдлаар шинэ ажлын байр 766 үүнээс байнгын ажлын байр 430, улирлын ажлын байр 44, түр ажлын байр 292 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 719, зуучлал 693 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 112 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан.

Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй-7, бага-18, суурь-142, бүрэн дунд-559, техникийн болон мэргэжлийн анхан шатны-21, тусгай мэргэжлийн дунд-16, Дипломын бакалаврын-132 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 16 иргэнийг LMIS программд шивж оруулан тодорхойлолт гарган агч Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 9-р сарын 25-ны байдлаар нийт 13.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.1 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14.5 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 41.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 4173.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 13.8 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 тэрбум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

Тэтгэврийн даатгалын санд 66.4 % буюу 10084.6 сая төгрөг

Тэтгэмжийн даатгалын санд 7.3 % буюу 914.9 сая төгрөг;

ҮОМШӨ-ний даатгалын санд 5.6 % буюу 506.7 сая төгрөг;

Ажилгүйдлийн даатгалын санд 1.5 % буюу 177.5 сая төгрөг;

Эрүүл мэндийн даатгалын санд 19.2% буюу 2210 сая төгрөг

2020 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 45.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 7.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Мал аж ахуйн салбарын өвөлжилтын бэлтгэл ажлыг хангуулахад энэ онд зуншлага оройтож болсны улмаас орон нутгаасаа өвс хадлан бэлтгэх боломж хомсдож бэлтгэвэл зохих өвс хадлангийн 50-60 хувийг авах боломжтой бусдыг нь гадны аймаг сумаас бэлтгэх, эсвэл худалдан авах шаардлагатай байгаа бөгөөд аймгийн аюулгүй нөөц бүрдүүлэхэд 200 тн өвс, 200 тн ногоон тэжээл, 100 тн хивэг худалдан авахаар шийдвэрлүүлсэн.

Аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийг бүрдүүлэхээр мал хамгаалах сангаас 30.0 сая, орон нутгийн хөтөлбөр хэрэгжүүлэх сангаас 70.0 сая, нийт 100.0 сая төгрөгөөр 250 тн өвс худалдан авахаар шийдвэрлүүлж Сэлэнгэ аймгаас бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Малчдын түвшинд байгалийн хадлан 12000 тн, гар тэжээл 280 тн бэлтгэсэн. Сумдын аюулгүй нөөцөд Хангай, Хайрхан сумдад 5.2 тн өвс, 1.3 тн тэжээл 1.5 тн хужир шүү нөөцөлсөн байна. Малын тэжээлийн зориулалтаар 3.0 мянган га-д малын тэжээлийн ургамал тариалсан, мөн улаан буудайн ургац алдсан талбайг тэжээлд шилжүүлэн тооцвол 7.0-8.0 мянган тн тэжээлийн ургамал хураан авах боломжтой байна.

Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 7 сумын 553 малчин өрхийн 193.6 мянган толгой мал, аймаг, орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц нутагт 3 сумын 46 малчин өрхийн 30.9 мянган толгой мал, Дорнод, Төв, Булган аймгийн нутагт 2 сумын 7 малчин өрхийн 3695 толгой мал отроор өвөлжинө.

Газар тариалан

Аймгийн хэмжээнд ургацын урьдчилсан балансаар, улаан буудай 1 га-гаас 10-12 цн, нийт 6795 га талбайгаас 7688 тн, тэжээл 1 га-гаас 25 цн нийт 3844 га талбайгаас 9612 тн, тосны таримал 1 га-гаас 8 цн, нийт 901 га талбайгаас 720.8 тн, төмс 1 га-гаас 100 цн, нийт 267.1 га талбайгаас 2671 тн, хүнсний ногоо 1 га-гаас 105 цн, нийт 139.5 га талбайгаас 1520.7 тн-ийг тус тус хураан авахаар байна.

Энэ намрын ургац хураалтанд үр тарианы комбайн 25, ангилан хадагч жатка 31, будаа цэвэрлэгч 5, үр сортлогч 1, будаа ачигч 7, төмс ухагч 24 зэрэг техникүүдийг ургац хураалтаас өмнө засвар үйлчилгээг нь хийж техникийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлал

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Өгийнуурт дотоодын аялагчдын тав тухыг хангах, боловсон 00, душ, гал түлэх, майхан барих цэг, машины зогсоол, морины уяа, спорт талбай бүхий отоглох цэгийг “Фамили фарнерс” ХХК гүйцэтгэж байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 9-р сарын 01-нээс 12-р сарын 20-ны хугацаанд зохион байгуулж байгаа “Яндангаа хөөлье” аяны хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хангайн нурууны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа, Орхон Чулуут голын сав газрын хамтран төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Байгалийн нөөц баялаг ашиглан үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний 4 төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 3 булгийн эхийг хашиж хамгааллаа.

“Нөхөн сэргээлт-2020” арга хэмжээний хүрээнд Цэнхэр сумын Орхон багт “БМНС” ХХК тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу 15 га талбайд техникийн, 13 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Барилга, дэд бүтэц

Архангай аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр 79 тэрбум 378.9 сая төгрөгийн өртөг бүхий 41 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 955.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 1 тэрбум 703.6 сая төгрөгийн өртөг бүхий 22 төсөл арга хэмжээ, нийт 82 тэрбум 37.5 сая төгрөгийн өртөг бүхий 71 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрдэнэбулган сумын хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, Жаргалант сумын Хоолт багийн бага сургуулийн барилга, 8 суманд мал угаалгын ванн барих ажлыг тус тус ашиглалтад хүлээн авсан.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----